



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 12 өдөр

Дугаар 1/190

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн Чингис хотын ундны усан хангамжийн эх үүсвэрийг орон нутгийн хамгаалалтад оруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Ц. Идэрбат	-Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын Захирагч
Нарийн бичгийн дарга:	Д.Жамбаа	-Хэрлэн голын сав газрын захиргааны даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч
Гишүүд:	Г.Мөнх-Эрдэнэ	-Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын уул уурхай, тусгай хамгаалалт хариуцсан мэргэжилтэн
	Н.Оюунмандал	-Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын усны мэргэжилтэн
	Ц.Билэгсайхан	-Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын кадастрын мэргэжилтэн
	Т.Баатарсүх	-Хэрлэн голын сав газрын захиргааны гадаргын ус хариуцсан ахлах мэргэжилтэн
	З.Урангоо	-Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын газрын даамал
	Б.Бямбасүх	-Хэнтий-Ус ХХК-ийн ус ашиглалтын инженер
	Г.Эрдэнэ-Очир	-Усны мэргэжлийн байгууллага "Буян Уул" ХХК-ийн захирал

01 958

2//.

2. Чингис хотын ундны усан хангамжийн эх үүсвэрийн газрын доорх усны тэжээгдлийн мужийн зургийг зураглаж, орон нутгийн хамгаалалтад авах санал боловсруулж, Хэрлэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж батлуулахыг ажлын хэсгийн ахлагч /Ц.Идэрбат/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА